



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/84

Төгөл

**Газар эзэмших эрхийн гэрчилгээ
нөхөн авах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187, 2023 оны А/133 дугаар Тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Хотгойд овгийн Өлзийхутагийн Эрдэнэбаяр (РХ75082114)-ын хүсэлтийн дагуу тус сумын 5 дугаар баг урд Төгөл байршилтай шатахуун түгээх газар, агуулахын зориулалттай 2255м² газрыг сумын Засаг даргын 2009 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн №63 тоот шийдвэрээр эзэмшиж авсан ба газрын цахим системд 6727001042 нэгж талбарын дугаартай бүртгэгдэн баталгаажсан бөгөөд уг газар нь газар эзэмшүүлэх шийдвэрт нэр нь дурдагдаагүй байх тул газар эзэмших эрхийн гэрчилгээг 15 жилийн хугацаатайгаар нөхөн олгосугай.
2. Уг Захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2009 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн №63 тоот шийдвэрээр бичигдэн 0176889 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосугай.
3. Иргэн Ө.Эрдэнэбаяртай шинээр газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг сумын газрын даамал (Ө.Нямхишиг)-т даалгасугай.
4. Сумын Засаг даргын Захирамжийг эс зөвшөөрвөл Захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны Улсын байцаагч (Г.Батчимэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.БАТБАЯР

9072294 671511403